



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/180-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС стандарт	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШУ	Шинжлэх ухаан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СПОРТЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
О.НАРАНБААТАР ТАНАА**

2025.08.25 № 10А-2025/100/НА-СТА-ТНБ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спорт сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/389 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж, 17,643.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

432502287

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	198,407,033.55	348,349,410.76
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	88,317,626.48	217,914,097.63
10	Төрийн сангийн харилцах	88,317,626.48	217,914,097.63
27	АВЛАГА	122,065.50	88,438,478.34
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	120,851.86	120,851.86
35	Байгууллагаас авах авлага	1,213.64	0.00
60	БАРАА МАТЕРИАЛ	109,967,341.57	130,314,461.27
67	Бичиг хэргийн материал	606,000.00	108,000.00
72	Хүнсний материал	1,932,049.50	4,157,094.00
73	Бусад хангамжийн материал	107,429,292.07	126,049,367.27
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	672,274,998.59	993,336,770.15
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	672,274,998.59	993,336,770.15
108	Биет хөрөнгө	640,474,998.59	961,118,770.14
109	Барилга, байгууламж	543,577,906.86	543,577,906.86
110	Хуримтлагдсан элэгдэл	-93,058,710.00	-111,670,452.00
111	Авто тээврийн хэрэгсэл	33,600,000.00	298,550,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	-12,950,000.00	-19,909,895.83
113	Машин, тоног төхөөрөмж	201,478,087.23	277,826,324.42
114	Хуримтлагдсан элэгдэл	-137,081,620.72	-128,389,905.77
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,206,824.60	186,075,572.60
116	Хуримтлагдсан элэгдэл	-86,117,393.72	-101,343,987.68
122	Бусад үндсэн хөрөнгө	11,178,159.74	11,178,159.74
123	Хуримтлагдсан элэгдэл	-4,584,171.00	-5,501,005.20
125	Номын фонд	10,225,915.60	10,726,053.00
126	Биет бус хөрөнгө	31,800,000.00	32,218,000.01
127	Програм хангамж	1,000,000.00	1,440,000.00
128	Хасагдуулга	-1,000,000.00	-1,021,999.99
129	Бусад биет бус хөрөнгө	31,800,000.00	31,800,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	870,682,032.14	1,341,686,180.91
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	6,344.00	0.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	870,675,688.14	1,341,686,180.91
215	Засгийн газрын хувь оролцоо	870,675,688.14	1,341,686,180.91
217	Өмч: -Төрийн өмч	174,356,190.32	174,356,190.32
223	Хуримтлагдсан үр дүн	641,027,130.16	1,112,037,622.93
224	Өмнөх үеийн үр дүн	641,027,130.16	641,027,130.16
225	Тайлант үеийн үр дүн	-	471,010,492.77
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,292,367.66	55,292,367.66
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	870,682,032.14	1,341,686,180.91

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,374,278,018.15	2,331,254,455.30
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,316,316.32	450,128,000.60
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,691,300.00	22,234,500.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,691,300.00	18,904,500.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	3,330,000.00
92	Бусад орлого	-	35,000.00
96	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	86,247,290.60	383,707,505.40
97	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	13,377,725.72	44,150,995.20
113	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,240,961,701.83	1,881,126,454.70
114	Улсын төвлөрсөн төсвөөс	957,630,100.00	1,586,045,100.00
131	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,331,601.83	295,081,354.70
132	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	283,331,601.83	295,081,354.70
149	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,308,088,598.62	1,856,256,313.03
150	УРСГАЛ ЗАРДАЛ	1,308,088,598.62	1,856,256,313.03
151	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,285,872,611.12	1,817,646,617.83
152	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	756,726,369.55	1,131,224,038.71
153	Цалин	520,330,293.56	714,158,966.85
154	Нэмэгдэл цалин	213,494,775.99	338,090,121.86
155	Унаа хоолны хөнгөлөлт	-	41,296,000.00
156	Урамшуулал	22,901,300.00	37,678,950.00
159	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,548,929.10	133,071,832.28
160	Тэтгэврийн даатгалын шимтгэл	63,962,171.93	90,948,111.99
161	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,516,563.88	11,234,444.01
162	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,012,049.55	5,801,489.21
163	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,445,749.56	5,004,507.91
164	Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,612,394.18	20,083,279.16
166	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,748,501.83	276,081,354.70
167	Гэрэл цахилгааны зардал	10,201,238.79	14,201,143.70
168	Түлш, халаалтын зардал	208,296,783.04	250,475,811.00
169	Цэвэр, бохир усны зардал	6,250,480.00	11,404,400.00
172	Хангамж, бараа материалын зардал	4,304,864.08	25,572,604.00
183	Нормативт зардал	48,216,890.50	72,008,597.00
187	Эд хогшил, урсгал засварын зардал	10,796,700.00	15,796,000.00
196	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,954,100.00	16,429,513.17

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

197	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,337,100.00	2,935,500.00
202	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	4,617,000.00	13,494,013.17
211	Бараа үйлчилгээний бусад зардал	140,576,256.06	147,462,677.97
212	Бараа үйлчилгээний бусад зардал	45,526,866.86	53,560,783.63
213	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,036,860.00	9,720,810.00
214	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,012,529.20	84,181,084.34
226	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,215,987.50	38,609,695.20
234	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,215,987.50	27,141,495.20
238	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	11,468,200.00
270	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	66,189,419.53	474,998,142.27
278	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,987,649.50
279	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,987,649.50
289	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-3,987,649.50
290	НИЙТ ҮР ДҮН	66,189,419.53	471,010,492.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,274,653,001.83	1,903,395,954.70
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,691,300.00	22,269,500.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,691,300.00	22,234,500.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,691,300.00	18,904,500.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	3,330,000.00
92	Бусад орлого	-	35,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,240,961,701.83	1,881,126,454.70
111	Улсын төвлөрсөн төсвөөс	957,630,100.00	1,586,045,100.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,331,601.83	295,081,354.70
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,268,010,899.48	1,748,276,483.55
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,268,010,899.48	1,748,276,483.55
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,245,102,961.98	1,708,445,878.35
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	756,726,369.55	1,131,797,038.76
151	Үндсэн цалин	520,330,293.56	714,731,966.90
152	Нэмэгдэл	213,494,775.99	338,090,121.86
153	Унаа хоолны хөнгөлөлт	-	41,296,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	22,901,300.00	37,678,950.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	93,550,142.74	132,497,618.59
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	63,963,385.57	90,373,898.30
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,516,563.88	11,234,444.01
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,012,049.55	5,801,489.21
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,445,749.56	5,004,507.91
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,612,394.18	20,083,279.16

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	256,337,291.83	276,081,354.70
165	Гэрэл цахилгааны зардал	10,201,238.79	14,201,143.70
166	Түлш, халаалтын зардал	239,885,573.04	250,475,811.00
167	Цэвэр, бохир усны зардал	6,250,480.00	11,404,400.00
181	Нормативт зардал	49,212,880.00	73,012,731.50
185	Эд хогшил, урсгал засварын зардал	26,994,310.00	19,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,954,100.00	16,429,513.17
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,337,100.00	2,935,500.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,617,000.00	13,494,013.17
208	Бараа үйлчилгээний бусад зардал	55,327,867.86	59,627,621.63
209	Бараа үйлчилгээний бусад зардал	48,398,587.86	48,688,817.63
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	6,929,280.00	10,938,804.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,907,937.50	39,830,605.20
225	Бусад урсгал шилжүүлэг	22,907,937.50	39,830,605.20
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	22,907,937.50	28,362,405.20
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	11,468,200.00
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,642,102.35	155,119,471.15
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	15,870,000.00	25,523,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,870,000.00	25,523,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	15,870,000.00	25,523,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,870,000.00	25,523,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,870,000.00	-25,523,000.00
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-9,227,897.65	129,596,471.15
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,545,524.13	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,317,626.48	129,596,471.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	574,837,710.63	804,486,268.61
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	574,837,710.63	804,486,268.61
5	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	66,189,419.53	66,189,419.53

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	641,027,130.16	870,675,688.14
7	2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	641,027,130.16	870,675,688.14
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	641,027,130.16	870,675,688.14
10	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	471,010,492.77	471,010,492.77
11	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	174,356,190.32	55,292,367.66	1,112,037,622.93	1,341,686,180.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,989,740,500.00	1,773,799,483.55	215,941,016.45	89.1
2	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,989,740,500.00	1,773,799,483.55	215,941,016.45	89.1
4	Бараа, үйлчилгээний зардал	1,945,391,100.00	1,733,968,878.35	211,422,221.65	89.1
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,267,383,200.00	1,131,797,038.76	135,586,161.24	89.3
6	Үндсэн цалин	840,180,600.00	714,731,966.90	125,448,633.10	85.0
7	Нэмэгдэл	400,368,700.00	338,090,121.86	62,278,578.14	84.4
8	Унаа, болон бусад нөхөн олговор	-	41,296,000.00	-41,296,000.00	-
9	Урамшуулал	26,833,900.00	37,678,950.00	-10,845,050.00	140.4
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,422,900.00	132,497,618.59	25,925,281.41	83.6
12	Тэтгэврийн даатгал	107,727,600.00	90,373,898.30	17,353,701.70	83.8
13	Тэтгэмжийн даатгал	12,673,800.00	11,234,444.01	1,439,355.99	88.6
14	ҮОМШӨ ний даатгал	6,336,900.00	5,801,489.21	535,410.79	91.5
15	Ажилгүйдлийн даатгал	6,336,900.00	5,004,507.91	1,332,392.09	78.9
16	Эрүүл мэндийн даатгал	25,347,700.00	20,083,279.16	5,264,420.84	79.2
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,143,000.00	276,081,354.70	6,061,645.30	97.8
18	Гэрэл цахилгаан	16,400,000.00	14,201,143.70	2,198,856.30	86.5
19	Түлш, халаалт	254,943,000.00	250,475,811.00	4,467,189.00	98.2
20	Цэвэр, бохир ус	10,800,000.00	11,404,400.00	-604,400.00	105.6
30	Нормативт зардал	93,757,100.00	73,012,731.50	20,744,368.50	77.8
32	Хоол, хүнс	93,757,100.00	73,012,731.50	20,744,368.50	77.8
34	Эд хогшил худалдан авах	19,000,000.00	19,000,000.00	-	100.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	28,546,700.00	16,869,513.17	11,677,186.83	59.0
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,935,500.00	2,935,500.00	-	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	25,611,200.00	13,934,013.17	11,677,186.83	54.4
53	Бараа үйлчилгээний бусад зардал	96,138,200.00	84,710,621.63	11,427,578.37	88.1
54	Бараа үйлчилгээний бусад зардал	85,122,100.00	73,771,817.63	11,350,282.37	86.6
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,016,100.00	10,938,804.00	77,296.00	99.3
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,349,400.00	39,830,605.20	4,518,794.80	89.8

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	32,881,200.00	28,362,405.20	4,518,794.80	86.2
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	11,468,200.00	11,468,200.00	-	100.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,989,740,500.00	1,903,360,954.70	86,379,545.30	95.6
99	Улсын төсвөөс санхүүжих	1,665,040,800.00	1,586,045,100.00	78,995,700.00	95.2
104	Орон нутгийн төсвөөс	301,143,000.00	295,081,354.70	6,061,645.30	97.9
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,556,700.00	22,234,500.00	1,322,200.00	94.3
111	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,226,700.00	18,904,500.00	1,322,200.00	93.4
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,330,000.00	3,330,000.00	-	100.0
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	129,596,471.15	-129,596,471.15	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	36.00	36.00	-	100.0
134	Удирдах ажилтан	1	1	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	25	25	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	10	10	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургууль нь “Багш, суралцагчийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, ёс зүйг эрхэмлэн суралцагч нэг бүрийн сурлага бие бялдрын хөгжил төлөвшилд ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Спортын төрөлжсөн хөтөлбөрийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж хагас жил тутам ахиц амжилтаа тодорхойлох,
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж сурагчдын сургалтын амжилтад ахиц гаргах,
- Сурагчийн хөгжил хамгааллын хөтөлбөр боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлж сурагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах,
- Хичээл үйл ажиллагаа амжилттай явагдах сургуулийн ээлтэй орчин хөтөлбөр боловсруулан эцэг эх, асран хамгаалагч, ажиллагсдын дэмжлэгтэй хэрэгжүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 471,004.2 мянган төгрөгөөр буюу 35.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
31	Мөнгөн хөрөнгө	88,317.6	217,914.1	129,596.5
33	Авлага	122.0	120.9	(1.1)
35	Бараа материал	109,967.3	130,314.5	20,347.2
39	Үндсэн хөрөнгө	672,275.1	993,336.7	321,061.6
3	Нийт хөрөнгө	870,682.0	1,341,686.2	471,004.2
4	Өр төлбөр	6.3	0.00	(6.3)
51	Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	870,675.7	1,341,686.2	471,010.5
6	Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	870,682.0	1,341,686.2	471,004.2

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 217,914.1 мянган төгрөг болж 129,596.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хэмнэлттэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 130,314.4 мянган төгрөг болж 20,347.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 148,694.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын ЗДТГ-аас гадна, дотно чиглэлийн камер суурилуулсан, БЕГ, Дэлхийн зөн ОУБ, бусад хандивлагч байгууллагуудаас нийт 44,150.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн зөвлөмжийн дагуу захирлын тушаалаар цаашид ашиглах боломжгүй 25,572.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан, 146,925.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 993,336.8 мянган төгрөг болж 321,061.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25,523.0 мянган төгрөгийн 17 ш таблет худалдан авч, БШУЯ, аймгийн Боловсролын газрын хөрөнгө

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан оруулалт, Дэлхийн зөн ОУБ-аас Хьюндай каунти автобус, өнгөт принтер, зөөврийн болон суурин компьютер, ухаалаг дэлгэц, цахилгаан махны машин, хөлдөөгч, уурын жигнүүр, тоос сорогч, угаалгын машин, хяналтын камер, сурах бичиг зэрэг нийт 383,707.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, сумын ИТХ-ын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 90 дүгээр тогтоолыг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй 102,271.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан, 84,181.1 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,611,745.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 489,696.7 мянган төгрөгөөр бууруулан 1,122,048.2 мянган төгрөгөөр баталсан боловч төсвийн жилийн дундуур төсөвт 7 удаагийн зохицуулалт хийгдэж улсын төсвөөс улсын төсвөөс 1,665,040.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 301,143.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,226.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,330.0 мянган төгрөг, нийт 1,989,740.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 1,586,045.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 295,081.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 18,904.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,330.0 мянган төгрөг, нийт 1,903,360.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, 1,773,799.4 мянган төгрөгийг зарцуулж, 129,561.5 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,773,799.4 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 145,254.0 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 4,518.8 төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардлыг 45,106.9 мянган төгрөгөөр, Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн зардлыг 7,128.2 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардлыг 3,057.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,917.3	2,917.3	0.0	100.0
2	80233 Хүүхэд хамгаалал	3,087.0	1,735.0	1,352.0	56.2
3	80312 - Сургалт семинар	2,477.1	2,360.0	117.1	95.3
4	81605 - Эрүүл мэндийг дэмжих	3,066.9	1,275.0	1,791.9	41.6
5	81801 - Үдийн цай хөтөлбөр	32,881.2	28,362.4	4,518.8	86.3
6	81806-Дотуур байрны үйлчилгээ	262,818.2	217,711.3	45,106.9	82.8
7	81816 Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	19,129.5	19,129.5	0.0	100.0
8	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	7,978.2	850.0	7,128.2	10.7
9	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,282,680.0	1,137,425.1	145,254.0	88.7
10	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	44,856.6	41,799.5	3,057.1	93.2
11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	20,191.2	20,175.8	15.4	99.9
12	81848-Сурах бичиг түрээс	2,935.5	2,935.5	0.0	100.0
13	81875 Сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	3,148.8	1,611.7	1,537.1	51.2
14	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	430.0	430.0	0.0	100.0
Дүн		1,688,597.5	1,478,718.1	209,879.4	87.6
15	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	301,143.0	295,081.3	6,061.7	98.0
Нийт		1,989,740.5	1,773,799.4	215,941.1	89.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Өсөх эрдэнэт сүрэг” ХХК оролцогч материал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй тул “Сэлэнгэ баян уул” ХХК, “Цахим Ертөнц” ХХК, “Туж ананд”, “Ундрах Тум” ХХК-иуд болон иргэн Ц.Ягаан, Н.Цэрэнлхам, Д.Баатар, Д.Мөнхцэцэг, Ц.Оюун-Эрдэнэ нартай гэрээ шууд байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари фاینэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа, чанарын хяналтыг захирал Д.Ариунаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын “Спортын” сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари фاینэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,308,088.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,621.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 169 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг завсрын аудитад хамруулаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 6,500.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- 4 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэснийг залруулж бүртгэсэн.

Аудитаар 1 зөрчил илэрч зөвлөмж өгөв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагын улмаас нягтлан бодогчоор хүний нөөцийн ажилтанг хавсруулан гүйцэтгэсэн гэх үндэслэлээр албан тушаалын цалингийн 25.0 хувиар тооцон хавсран ажилласны нэмэгдэл цалин олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн.	1	6,500.0			1	6,500.0	1	6,500.0				

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

